



УВС АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2015 оны 06 сарын 11 өдөр

Дугаар 4/83

Улаангом

2015 оны орон нутгийн төсөвт өөрчлөлт  
оруулахыг дэмжих тухай

Аймгийн Засаг даргын зөвлөлийн 2015 оны 06 сарын 10-ны өдрийн хурлаас гарсан саналыг хэлэлцээд Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20.1.7, Төсвийн хуулийн 64.1.2 дахь заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Хархираа амралтын газрын 10 кВ-ын ЦДАШ, 10/0,4 кВ-ийн дэд өртөөний угсралтын ажлын зөрүү 78666287 төгрөг, Наадмын талбайн авто зогсоолын барилгын ажлын зөрүү 316443853 төгрөгийг 2016 оны ОНХС-ийн эх үүсвэрт тусгаж батлуулахыг СТСХэлтэс /Ч.Энхбаяр/-т даалгасугай.
2. Аймгийн ИТХ-ын 2015 оны 8/05 дүгээр тогтоолын 2-р хавсралтын 1 дэх заалтад "Аймгийн хилийн зааг дээр мэдээллийн самбар 3, аймгаас сум, сумаас сум хоорондын замууд дээр чиглэлийн 42 тэмдэг, 10 сая төгрөг" гэснийг өөрчилж "Аймгийн хилийн зааг дээр мэдээллийн самбар 3, аймгаас сум, сумаас сум хоорондын замууд дээр чиглэлийн 10 тэмдэг, 10 сая төгрөг" болгон өөрчлөхийг дэмжсүгэй.
3. Аймгийн ИТХ-ын 2015 оны 9/01 тогтоолын 3-р хавсралтын 1.1.2 дахь заалтын Цэдэнбалын талбайн тохижилт 69,4 сая. төг, Увс нуур, Улаан уул орчинд нийтийн ариун цэврийн байгууламж барих" 40,0 сая төгрөг гэсэн заалтыг хасаж, Увс нуурын хөвөөнд ариун цэврийн байгууламж барих 20 сая төгрөг, Бөхийн өргөөний ариун цэврийн өрөө сайжруулах, гадна хаалга шинэчлэхэд 16 сая төгрөг, Бадрахын гудамжны явган хүний зам талбай, зүлэгжүүлэлт 11,0 сая төгрөг, Хог булшлах ажлын дутуу 24,2 сая төгрөг, Аймгийн ЗДТГ-ын ариун цэврийн өрөөг сайжруулан засварлах 15,0 сая төгрөг, Ю.Цэдэнбалын талбайн усан оргилуур, сандал, цэцгийн мандлын ховхорч унасан өнгөлгөөний хиймэл гантиг зэргийг сэргээн засварлах 13,2 сая төгрөг, Эдийн засгийн чуулганы зардалд дэмжлэг 10,0 сая төгрөг гэж өөрчлөхийг дэмжсүгэй.

ДАРГА



Ч.ЧИМЭД